

ТАНИЛЦУУЛГА

Журам, маягтын загвар батлах тухай хамтарсан тушаалын төсөл боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2-т “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын дэвтэр, эмнэлгийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг, оршуулгын тэтгэмжийг нас барсан тухай гэрчилгээг үндэслэн олгоно”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3-т “Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журмыг нийгмийн даатгалын төв байгууллагад тогтооно.” гэж тус тус заасан.

Дээрх хуулийн заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”- ыг баталж мөрдөн ажиллаж байна.

Уг тушаал нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Эмнэлгийн хуудасны маягтын загвар, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам, маягтын загвар батлах тухай” хамтарсан тушаалын төслийг боловсруулав.

Нийгмийн даатгалын сангаас 2023 оны 10 дугаар сарын байдлаар 170 мянган даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авахаар эмнэлгийн хуудас бичүүлсэн байна.

Энэхүү журамд эмнэлгийн хуудсыг цахимаар олгох тухай зохицуулалтыг тусгав.

Эмнэлгийн хуудас цахимжсанаар дараах үр дүн гарч байна. Үүнд:

-даатгуулагч, иргэн эмнэлгийн хуудсыг цахимаар түргэн шуурхай, ил тод, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах;

-эмнэлгийн хуудасны олголт, шийдвэрлэлт хэрхэн явагдаж байгааг цахимаар хянах боломж бүрдэх;

-төрийн байгууллагууд холбогдох програмтай байх, ашиглах;

-байгууллагуудын дундын програмд мэдээллийг цаг алдахгүй түргэн шуурхай ил тод нээлттэй болгосон байх;

-хяналтын системийг хэрхэн бүрдүүлж шийдвэрлэж ажиллах зэрэг тус тус болно.

Эмнэлгийн хуудас цахимжсанаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас олгох үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, 170 мянган даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох үйл ажиллагааг чирэгдэлгүй хүргэх, цаг хугацаа зардал хэмнэх, гомдол маргааныг шуурхай шийдвэрлэх, хяналтыг сайжруулах, ил тод болгох зэрэг олон эерэг өөрчлөлт гарч байна.

Энэхүү тушаал батлагдсанаар улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт, зардал шаардлагагүй болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын “Журам, маягтын загвар батлах тухай” хамтарсан тушаалын төсөлд танай саналыг тусган хамтран батлахаар хүргүүлэв.

- - - оОо - - -

